



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/103

Сүхбаатар сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 тоот тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 4.4, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргасан иргэдийн жагсаалтыг хавсралтаар баталж, 2,4,6,7 дугаар багийн 4 иргэний 2873 м² газрын эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.


2. Дээрх газарт кадастрын зураглал хийн холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож газар эзэмших эрх зүйн харилцаа үүсгэн, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултегс/-д даалгасугай.

3. Эзэмшилд олгогдсон газраа тохижуулж хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4. Газар эзэмшигчийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д хариуцуулсугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/247, 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/369, 2012 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/69, 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 408 тоот захирамжид холбогдох заалт, гэрээ, гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801338